



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/428

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, 2023 оны 23 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 29 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4 дэх зорилтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй "Галдан бошогт хааны онгоны тахилга"-ын арга хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Тонхил суманд зохион байгуулсугай.

2. Тус арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 41,966,100 (дөчин нэгэн сая есөн зуун жаран зургаан мянга нэг зуу) төгрөгийг "Галдан бошигт хааны онгоны тахилгын арга хэмжээний бэлтгэл хангах" батлагдсан эх үүсвэрээс зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

